

Батлал-2
 В-Р Хөтөө, 1-р багт
 НЭХ-

БАТЛАВ.
 НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД
 ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
 /Ц.ТУЛГА/

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар:МЗХ2021/10-032

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны 03 дугаар 29-ний өдрийн 3/1092 дугаартай албан бичиг - Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 6/705 дугаартай албан бичиг.
2	Тохижилтын ажлын нэр /төрөл/ байршил	<p>Гадна талбайн нэгдсэн тохижилт; Сүхбаатар дүүргийн 08 дугаар хорооны нутаг дэвсгэрт</p>
3	Тохижилт хийх газрын хэмжээ /Зориулалт/	Нийтийн эдэлбэр газарт
4	Төслийн захиалагч	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Төсөл боловсруулах үе шат	Төслийг хоёр үе шаттай боловсруулна. -Судалгаа, загвар зураг (2 хувь А4, А3 хэмжээтэй, CD) -Ажлын зураг
7	Төлөвлөлтийн орон зайд тавигдах шаардлага	Архитектур орон зайн төлөвлөлтийг эзэмшил газартай эсэх талаар тодруулга авч Нийслэл хотын онцлог, шаардлага, орц гарц, орчны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, тохижилтын төлөвлөлттэй уялдуулан холбогдох хууль, норм ба дүрмийг мөрдлөг болгох. Ногоон байгууламж: - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт (БНБД 30-01-04)-ийн 4-т заасны дагуу нийтийн хэрэгцээний болон тусгай зориулалттай ногоон байгууламж төлөвлөх - Ногоон байгууламж болон зүлэгжүүлэн тохижуулах байршил, талбайн хэмжээг батлагдсан ерөнхий төлөвлөгөө, тухайн хорооны нутаг дэвсгэрийн онцлог, нийтийн тээврийн үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл зориулалтад тохируулан оновчтой сонгон төлөвлөх - Төлөвлөлтийг хийхдээ Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн шаардлага (UCS 0801A:2020)-д нийцүүлэх -Байгалийн ландшафтын онцлог ба экологийн систем түүний аюулгүй байдал, тэнцвэртэй байдлыг хадгалан хамгаалах, сэргээх, арчлах, шаардлагатай тохиолдолд хуучин байсан ургамал, мод сөөг зэргийг өөр байршилд шилжүүлэхийг зөвшөөрнө - Мод, сөөг, ургамлын төрөл зүйлийн сонголтыг Мод, таримал ургамалын төрөл зүйлийн лавлах (UCS 0803A:2020)-ийг судлан байршиж буй бүс нутгийн уур амьсгалын нөхцөл, цэцэрлэгжүүлэлтийн зориулалт, нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нөхцөл ургамлан нөмрөгийн байдалд тохируулж, тэдгээрийн өнгө, титмийн хэлбэрийг оновчтой сонгон төлөвлөх - Тухайн хорооны нутагт орхигдсон газар, ногоон байгууламжид тулгарч буй экологийн асуудал, тэдгээрийн шалтгааныг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, дүн шинжилгээ хийлгэж,

		<p>экологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай байршлуудыг тогтоон нөхөн сэргээлт хийх</p> <ul style="list-style-type: none"> - Спорт, фитнесийн цэцэрлэгт хүрээлэн төлөвлөх боломжтой <p>Явган зам, талбай:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль 12.6.1. /гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, уран барилгатай нь уялдуулан, тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байх/ -ийг мөрдлөг болгох - Явган зам, талбайг төлөвлөхдөө Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт (БНБД 30-01-04)-ийг баримтлан явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага (UCS 0901B:2020)-д нийцүүлэн төлөвлөх - Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар (MNS 6056:2009)-стандарт, Тахир дутуу хүнд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль (БД 31-101-04), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар (БД 31-112-11) норм стандартын шаардлага хангасан замын өргөн, орон зайтай байх - Нийтийн эзэмшлийн талбай, авто зогсоол, нийтийн тээврийн зогсоол, цэцэрлэгт хүрээлэн болон авто зам дагуу байрлах явган замыг төлөвлөхдөө зорчигчийн аюулгүй байдлыг хангах, саадгүй зорчих нөхцөл бүрдүүлэх, ая тухтай, орон зай хангалттай, тэмдэг тэмдэглэгээ бүрэн бүтэн байж хүртээмжтэй төлөвлөлт хийх - Явган зорчигчдын тав тухтай зорчих нөхцөлийг хангахын тулд ихэвчлэн налуу зам төсөллөнө тодорхой байршлуудад явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага (UCS 0901B:2020)-д нийцүүлэн шат төлөвлөхийг зөвшөөнө - Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж явган зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулж орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх <p>Дугуйн зам, зогсоол:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль 12.6.1-ийг мөрдлөг болгох - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт (БНБД 30-01-04)-ийг баримтлан Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага (MNS 5683:2016) болон унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага (UCS 0903B:2020)-д нийцүүлэн төлөвлөх <p>Авто зам, зогсоол:</p> <ul style="list-style-type: none"> - Авто замыг, зогсоолыг барьж байгуулахдаа Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандах - Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөхдөө тухайн орчмын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага (UCS 0902B:2020)-д нийцүүлэн төлөвлөх <p>Хүүхдийн тоглоомын талбай:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага (UCS 0001-01:2019) мөрдөх - Тоглоомын аюулгүй байдлын стандартыг хангах; MNS ISO8124-1:2011, MNS ISO8124-2:2011 MNS ISO8124-3:2011, MNS ISO8124-4:2011 - Хүүхдийн тоглоомын талбайг хүүхдийн насны онцлог тохируулан, танин мэдэхүйн зориулалттайгаар ангилан
--	--	---

		<p>хэрэгслийн зогсоолын төлөвлөлт (БД 32-101-37), Нийтийн тээвэр Замналын зогсоол, Ангилал.Техникийн шаардлага (MNS 5879:2012), Нийтийн тээврийн хэрэгслийн зогоолд тавигдах шаардлага (UCS 1601B:2020)–д нийцүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Бүх төрлийн талбайд мэргэжлийн хяналтаар баталгаажсан сайн чанарын тоног төхөөрөмж тавьж, Олон улсын стандартад нийцсэн хэмжээтэй төлөвлөх - Хүний анхан шатны хэрэгцээ болох цэвэр ус уух цорго төлөвлөх
8	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах, инженерийн шугам сүлжээний засвар, арчлалтын арга хэмжээтэй уялдсан төлөвлөлтийн шийдлийг сонгох - Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны байгууламжуудтай нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх
9	Төслийн иж бүрдэл	<p>Зургийн иж бүрдэл:</p> <p><u>Зурган мэдээлэл, судалгаа,</u></p> <ul style="list-style-type: none"> - Одоогийн байдал, судалгааны танилцуулга - Байршлын схем M1:10000 - Орчны тойм M1:5000 - Байрзүйн дэвсгэр зураг M1:500 - Одоогийн байгаа явган зам, талбай, автозамын сүлжээ M1:1000 - Одоогийн ногоон байгууламжийн байгуулалт /Дендрологийн байгуулалт/ <p><u>Төлөвлөлтийн зураг</u></p> <ul style="list-style-type: none"> - Нүүр хуудас /Батлагдах хуудас/ - Төлөвлөлтийн танилцуулга /Архитекторын шийдэл/ - Гудамж замын сүлжээ M1:1000 - Ерөнхий төлөвлөгөө M1:1000 /Батлагдах хуудас/ - Хөдөлгөөний схем M1:2000 - Явган зам, авто зам талбайн байгуулалт - Гэрэлтүүлгийн байгуулалт - Харагдах байдал /Төлөвлөлтийн орчинд эвлүүлсэн зураглал/ - Дендрологийн байгуулалт - Дендрологийн шилжүүлсэн байгуулалт - Өндөржилт M1:1000 - Улаан шугам M1:5003 - Ус зайлуулах сувгийн зураг M1:1000 - Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас M1:1000 - Хог, хаягдалын төвлөрүүлж, тээвэрлэх, зөөвөрлөх цэгийн схем M1:2000 <p>Зураг төсөлд стандарт масштабыг хэрэглэнэ.</p>
10	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Хууль, дүрэм журмаар зөвшөөрсөн барилга, байгууламжийг барилгын норм ба дүрмийн дагуу, мэргэжлийн байгууллагын зөвшөөрснөөр төлөвлөх - Төслийг боловсруулахдаа эзэмшил газар, төлөвлөгдсөн авто зам байгаа эсэхийг тухайн хариуцсан байгууллагуудаас авч хамтран ажиллах - Зураг төслийн болон ажил гүйцэтгэх явцад тухайн нутаг дэвсгэрийн инженерийн шугам сүлжээний хариуцах байгууллагатай болон газар эзэмшигч холбогдох газруудтай зөвшилцөх - Амьд ургамлан хайсыг ногоон байгууламжийн хамгаалалт гоёл чимэглэлд хэрэглэх бөгөөд амрах хэсэгтэй уялдуулах.

бүсчлэх, зөрчилдөөнтэй үйлдлээс гарч болох эрсдлийг тооцон төлөвлөх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тоглох стандартын шаардлагыг хангасан орчин бүрдүүлэх

Чийрэгжүүлэх талбай:

- Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага (UCS 1403B:2020)-д нийцүүлэн төлөвлөх
АРХИТЕКТУРЫН БАГА ЭЛЕМЕНТҮҮД:

Хашаа хайс:

- Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс, барих, ашиглах, буулгах журмыг баримтлах мөн Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ (UCS 0001-02:2019)-д нийцсэн байх

- Дээрх журмын 5. Хашаа, хайс барихыг хориглох заалтуудыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг Нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага болон Нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдэж хамтран ажиллах

Гэрэлтүүлэг:

- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг (БНБД 23-02-08), Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг (БНБД 83-27-00) баримтлан Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага (UCS 1901B:2020)-д нийцүүлэн төлөвлөх

- Гэрэлтүүлэг нь аюулгүй орчныг бүрдүүлэх, оновчтой байршилтай, эдийн засгийн үр ашигтай, эрчим хүчний хэмнэлттэй, нарны эрчим хүчийг ашигласан эко байхаар төлөвлөх

- Мэргэжлийн хяналтаар баталгаажсан олон улсын шаардлагад нийцсэн дизайн загвар нь орчны тохижилтод нийцсэн сайн чанарын гэрэл төлөвлөх

- Тохижилтын талбайг гэрэлтүүлэх хангамжийн бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангагдах хэсгийн мэдээлэл, эх үүсвэрийн хүчин чадал, ачаалал зэргийг тооцож төлөвлөх

Сандал:

- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага (UCS 1404C:2020)-д нийцүүлэн төлөвлөх

Саравч, сүүдрэвч:

- Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага (UCS 1201C:2020)-д нийцүүлэн төлөвлөх

Хогийн сав:

- Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогийн саванд тавигдах шаардлага (UCS 1403C:2020)-д нийцүүлэн төлөвлөх

Бусад:

- Хяналтын камер, тэмдэг тэмдэглэгээ, спортын тоног төхөөрөмж, бусад элементүүдийг төлөвлөх

- Архитектур орон зайн төлөвлөлтөд нийцсэн тохижилтын элементүүдийг зорчих хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар төлөвлөх


- Хүндэтгэлийн, олон нийтийн, амралтын, спортын талбайг судалгаа шинжилгээ, эрэлт хэрэгцээнд тохируулж орчны төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх боломжтой, шаардлагатай гудамж талбайг автомашингүй болгон төлөвлөх боломжтой


- Нийтийн тээврийн зогсоол талбайг төлөвлөхдөө Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт (БНБД 30-01-04), Нийтийн тээврийн

		<p>- Гудамжны зорчих хөдөлгөөний орц, гарцыг судалж оновчтой байдлаар төлөвлөх.</p> <p>- Нисдэг тэрэг буух, нисэх талбай төлөвлөх боломжит байршлыг судлан, эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр төлөвлөх</p> <p>- Хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх шинэлэг загвар дизайн бүхий тохижилтын элементүүдийг төлөвлөх</p> <p>- Төлөвлөж буй талбайд инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас бүсэд хамрагдаж байгаа тул холбогдох хууль дүрэм журмын дагуу төлөвлөх.</p> <p>- Орчны өнгө үзэмж, ногоон байгууламж нэмэгдүүлэх шинэлэг загвар дизайн бүхий тохижилтын элементүүдийг төлөвлөх.</p> <p>- Борооны болон гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээ авах</p> <p>- Тохижилтын талбайг нэмэгдүүлэн төлөвлөх боломжийг судлан зураг төсөлд тусгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн төлөвлөх</p> <p>- Төлөвлөлтөд тусгагдсан шаардлагатай хэсгийн бетон болон явган замын хучилтыг хуулж, шаардлагатай хэсэгт хөрсийг нөхөн сэргээж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.</p> <p>- Төлөвлөлтөд саад болж буй одоо байгаа мод, бут сөөгний үндэсийг гэмтээхгүйгээр шилжүүлэн суулгах, Шилжүүлэх байршлыг тодорхой болгох</p> <p>- Гудамжны зорчих хөдөлгөөний орц, гарцыг судалж оновчтой байдлаар төлөвлөх.</p>
11	Захиалагчийн нэр, утас	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, М. Бямбасүрэн; Утас: 976 – 77070709;

Анхааруулга:

1. Монгол Улсын хуулиуд, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Усны тухай хууль, Бусад холбогдох хуулиуд, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, УИХ-ын 2013 оны 2-р сарын 08-ны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын 2020 оны ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг, Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, Норм, дүрэм, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/, Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар /УББ 11-202-00/, Барилгын орчны тохижилтын ажил /БНБД 3.01.06-90/, Бусад холбогдох норм, дүрмүүдийг баримтална.
2. Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:
 - Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх.
 - Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийг UTM48N /WGS84/ буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх.
 - Загвар зургийн эх сурвалж /AutoCAD, 3D MAX, Sketchup, Lumion/-ийн файлыг хүлээлгэн өгөх. Мөн material, texture хавсаргах.
3. Тохижилтын зураг төслийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалт, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд загвар зураг батлагдахгүй болно.
4. "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901B:2020, UCS 0902B:2020, UCS 0903B:2020, UCS 0001-01:2019, UCS 0001-02:2019, UCS 0002-02:2019, UCS 1901B:2020, UCS 1403C:2020, UCS 1404C:2020-г тус тус мөрдөх.


Хянасан: Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга  /Г.ДАЛАНЖАРГАЛ/

Боловсруулсан: Хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн  /А.ЭНХНАРАН/

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН СХЕМ ЗУРАГ

(дугаар: мэх 2021/10-032 зураг Боловсруулах даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Сүхбаатар дүүргийн 08-р хороо	СБДЗДТГ	Гудамж талбайн нэгдсэн тохижилт
643160 643440	643720 644000	644280



643160
Масштаб 1: 8,000

643440 643720 644000 644280
Тусгаг : WGS 1984 UTM Zone 48N

ТАНИХ ТЭМДЭГ

- ДУУССАН БАРИЛГА (Хаяг дугаартай)
- ДУТУУ БАРИЛГА (Хаяг дугаартай)
- ОДОО БАЙГАА БАРИЛГА (Хаяг дугааргүй)
- БАРИЛГА /Төлөвлөгдсөн/
- ДЭД БҮТЭЦ /Төлөвлөгдсөн/
- АВТО ЗАМ /Төлөвлөгдсөн/
- ТОХИЖИЛТ /Төлөвлөгдсөн/
- Газрын хэмжээ
- Дулааны шугам
- Цэвэр усны шугам
- Бохир усны шугам
- Холбооны шугам
- Төрийн ус зайлуулах шугам

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй байршил
2	Тусгаар тогтнолын ордон
3	Спортын төв ордон
4	Монгол улсын их сургууль
5	Авто зам, талбай

ТОХИЖИЛТЫН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар (м2)	XXX
Тохижилтын талбай (м2)	Нийтийн эдэлбэр
Байршлын дугаар :	-

(Зураг боловсруулах даалгаврын хамт хүчинтэй.)

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛЫГ
ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР /SHIP.DWG/-ЭЭР
ГАРГУУЛАН АВЧ НИЙТИЙН ЭДЭЛБЭР
ГАЗАРТ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
Хот төлөвлөлтийн хэлтэс

Нийслэлийн Засаг захиргааны 2-р байр 1101 тоот
Утас: 11-324975, website: <http://uda.ub.gov.mn>